

## ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

“Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай”  
хуулийн төслийн тухай

2018 оны 11 дүгээр  
сарын 16-ны өдөр

Дугаар11/01

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай” хуулийн төслийг (цаашид Хуулийн төсөл гэнэ) боловсруулан холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнаас санал авч, олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэг явуулж байна.

Энэ хуулийн төслийг 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 1-1/5017 дугаар албан тоотор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд санал авахаар хүргүүлжээ.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шинжээчид, холбогдох референтүүд хуулийн төсөлтэй танилцаад дараахь санал, дүгнэлтийг бэлтгэн танилцуулж байна. Мөн хуулийн төслийг хянахдаа одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн холбогдох заалтуудтай харьцуулав.

### **Нэг. Хуулийн нэрийн тухай**

Хуулийн төсөл бүхэлдээ иргэн шашин шүтэх эрхээ чөлөөтэй эдлэх, шашны байгууллагын үйл ажиллагаа, өмч хөрөнгө, бүтэц, зохион байгуулалт, эрх хэмжээ, шашин сурталчилах арга хэлбэр, гадаадын шашны байгууллагын үйл ажиллагаа, гадаадын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсад шашны үйл ажиллагаа явуулах эрхтэй холбоотой харилцааг зохицуулжээ. Хуулийн төслийн 5 бүлгийн 4 нь, 45 зүйлийн 40 нь, 281 хэсэг, заалтын 264 буюу 94 хувь нь шашны бүлэг, байгууллага, шашны номлол түгээгчийн харилцаатай зохицуулалт байна.

Гэтэл хууль “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай” гэсэн атлаа шашин эс шүтэгч иргэн уг эрх чөлөөгөө хэрхэн эдлэх эрхийн тухай зохицуулалт хуулийн төсөлд огт байхгүй байна. Хуулийн төсөлд шашин эс шүтэгч иргэн ямар үйл ажиллагаа явуулж болох, түүнийг хэрхэн зохион байгуулах, ямар эрх хэмжээтэй байх тухай нэг ч заалт байхгүй байна.

Ийнхүү иргэний шашин шүтэх эрх чөлөөг зохицуулсан атлаа эс шүтэх эрхийг орхигдуулан ялгаварласан Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” мөн зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэснийг шууд зөрчиж байна.

Үүнээс харахад Монгол Улсын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн Хоёрдугаар бүлгийн Арван зургаадугаар зүйлийн 15 дахь хэсэг “шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй” гэсэн заалтыг ашиглан зөвхөн шашин шүтэх эрх чөлөөг

хуульчлахыг оролдсон, эс шүтэх эрх чөлөөг орхигдуулсан “Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай” гэсэн нэртэйгээ нийцэхгүй өрөөсгөл хуулийн төсөл болжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Төр, сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулна” хэмээн шашны асуудалтай холбогдуулан “Төр, сүм хийд хоорондын харилцааг л хуулиар л зохицуулах”-аар заасан байхад, үүнийг үл хайхран Монгол Улсын Үндсэн хуулиар нэгэнт тунхаглан баталгаажуулсан шашин шүтэх, эс шүтэх үзэл санааны томъёоллыг хуулийн нэр болгон ашигласан байна.

### **Хоёр. Төр, шашны хоорондын харилцааны эрх зүйн зохицуулалт**

Монгол Улс хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөх зэрэг үзэл баримтлалыг тулгуур зарчмаа болгож, иргэнийхээ шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн Хоёрдугаар бүлгийн Арван зургаадугаар зүйлийн 15 дахь хэсэгт “шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй” хэмээн зааж, нэгэнт зохицуулсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Төр, сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулна” гэсэн бөгөөд Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль 1993 онд батлагдан мөрдөгдөж байна. Энэ хуулийн хүрээнд Монгол Улсад шашны үйл ажиллагаа зохицуулагдаж, Монгол Улсын иргэд шашин шүтэх, эс шүтэх эрхээ чөлөөтэй эдэлж байна. Тиймээс Үндсэн хуулиар иргэнд нэгэнт олгогдсон “эрх чөлөө”-г хууль гарган зохицуулалт хийх шаардлагагүй гэж үзэж байна.

Үндсэн хуулинд заасан Монгол Улсын иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө нь иргэн ямар ч үед (дайны болон онц байдлын үед ч хязгаалагдахгүй) баталгаатай эдлэх эрх юм. Нэгэнт Үндсэн хуулиар иргэнд баталгаатай эдлүүлэхээр заасан иргэний шашин шүтэх эс шүтэх, эрх чөлөөг дахин хууль гарган зохицуулалт хийх нь Монгол Улсын Үндсэн хуулийн Есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Төр, сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулна” гэж заасантай зөрчил үүсгэнэ.

Иймд одоо мөрдөгдөж байгаа Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг шинэчлэн найруулах замаар хийх нь Үндсэн хуулийн зарчимд нийцэх юм. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуулиар зарлан тунхагласан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангах баталгааг тогтоох...” гэсэн зорилт бий.

### **Гурав. Хуулийн төслийн тухай санал**

1. Хуулийн төслийн “Хуулийн зорилт” гэсэн 1 дүгээр зүйлд “иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх” гэсэн зорилт нь Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 15 дахь хэсэгт, мөн Хуулийн төслийн “шашин шүтлэгийн байдлаас хамаарч хүнийг ялгаварлан гадуурхахаас урьчилан сэргийлэх” гэсэн зорилт нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тус тус тусгагдсан байна. Үндсэн хуулинд тусгасан зохицуулалтыг дахин хууль гарган зохицуулах шаардлагагүй.

Тэгээд ч Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэн баталгаатай эдлэх 18 үндсэн эрх, эрх чөлөөнөөс “шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө”-г ялган авч хууль гаргавал бусад 17 эрх, эрх чөлөөг мөн ийнхүү хууль гарган зохицуулах жишиг үүснэ.

2. Хуулийн төслийн 2.2-т байгаа “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэсэн заалт нь ирээдүйд тодорхойгүй үр дагавар үүсгэх болно.

Хэдийгээр одоо мөрдөгдөж байгаа Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд ийм заалт байгаа боловч бидний анхаарах ёстой заалт мөн. Ирээдүйд шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй холбоотой ямар нэгэн олон улсын гэрээг Монгол Улс байгуулах буюу нэгдэн орж, түүнийг нь УИХ хүлээн авч соёрхон баталснаар тэр гэрээ нь хуулийн хүчин чадалтай гэрээ болж, энэ хуультай зөрчилдөх тохиолдолд тухайн олон улсын гэрээний заалт давуу хүчин чадалтай үйлчлэх болно. Түүний эерэг, сөрөг нөлөөг урьдчилан таамаглах аргагүй юм.

Дэлхийн улс төр, эдийн засгийн бодлогыг тодорхойлогч Их гүрнүүдийн зүгээс тодорхой зорилготойгоор шашны харилцаатай холбоотой олон улсын гэрээ байгуулах, тийм гэрээнд нэгдэн орох, түүнийг соёрхон батлахыг шаардах улс төр, эдийн засгийн шууд олон шууд бус шахалт, нөлөөллийг Монгол Улс тэсвэрлэх чадавхигүй байгааг анхаарах ёстой.

Иймд шашин шүтэх эрхтэй холбоотой олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, түүнийг УИХ-аар соёрхон батлах тодорхой шалгуур тогтоох нь зүйтэй.

3. Хуулийн төслийн 3.1-д хуулийн үйлчлэх хүрээг заахдаа “Шашны бүлэг, шашны байгууллага, шашны номлол түгээгчийн үйл ажиллагаа хамаарна” гэсэн нь уг хуулийн төслийн зөвхөн шашны бүлэг, байгууллага, шашны номлогчийн үйл ажиллагаанд л чиглэсэн болохыг харуулж, иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөнд хамааралгүйг нотолж байна.

“Шашны номлол түгээгч” гэдэг нь зарим нэг шашинд байдаг ойлголт бөгөөд тэдгээр нь өөрийн сүмээс гадуур явж шашнаа сурталчилж, иргэдийг шашиндаа элсүүлэх үйл ажиллагааг явуулдаг. Тэгвэл зарим шашин тухайлбал, буддын шашны сүм, хийд нь гадуур олон нийтэд хандаж шашны номлол түгээгчийг илгээж шашны үйл ажиллагааг сурталчлах болон иргэдийг өөрийн шашинд элсүүлэх үйл ажиллагаа зохион байгуулдаггүй. Буддын сүм, хийд нь зөвхөн зорьж ирсэн сүсэгтэн, шүтэгч нарт үйлчилгээ үзүүлдэгээрээ ялгаатай.

Ийнхүү зөвхөн зарим нэг шашны бүлэг, байгууллагын шашны ажилтан болох номлол түгээгчийн үйл ажиллагааг тухайлан хуульчилж өгч байгаа нь бусад шашныг ялгаварласан, улмаар давуу байдал үүсгэж байна. Энэ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэснийг шууд зөрчиж байна.

Хуулийн төсөлд шашны номлол түгээгчийг тусгайлан заасан атлаа хуулийн төсөлд байгаа “хандивлагч”, “дэмжигч”, “гадаадын иргэн”, “харьяалалгүй хүн”, “гадаад улсын шашны байгууллага”, “түүний салбар”, “төлөөлөгчийн газар”, “шашин шүтэгч иргэн”, “иргэд”, “хүүхэд”, “бага насны хүүхэд” зэрэг өөр олон субьектын эрх хэмжээ, тэдгээрийн үйл ажиллагааны зохицуулалтыг маш бүрхэг тусгасан, эсвэл тусгаагүй байна.

4. Хуулийн төсөлд нэр томъёоны тодорхойлолт байхгүй байгаа нь цаашид дураараар хуулийг тайлбарлах, улмаар маргаан зөрчил үүсэх нөхцлийг үүсгэнэ. Жишээлбэл, Хуулийн төслийн 4.2-т “иргэн шашны үйлсэд зүтгэх”, “шашны үйлчилгээ

үзүүлдэг бусад газар”, “шашны ёс зүйн болон бусад сургалт” гэснийг тодорхой тайлбарлах шаардлагатай. Мөн хуулийн төсөлд дурьдсан “мөргөлийн газар”, “мөргөлийн бусад газар”, “шашны сургууль”, “шашны хэвлэл мэдээллийн байгууллага”, “хэвлэх үйлдвэр”, “хандив”, “тусламж”, “дэмжлэг”, “өглөг” зэрэг нэр томъёог маш тодорхой томъёолох шаардлагатай.

5. Хуулийн төслийн 4.3-т зааснаар “Иргэн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журам гажуудуулж болохгүй” гэжээ. Энэ заалт зөвхөн шашин шүтэгч иргэнд хамааралтай болжээ. Хуульд заасан бусад субъектууд болох шашны бүлэглэл, байгууллага, гадаад улсын шашны байгууллага, түүний салбар, төлөөлөгчийн газар, шашны байгууллагын харьяа хэвлэл мэдээлэл, сургууль болон шашны номлол түгээгч зэрэг бусад субъектэд энэ заалтыг хамааруулаагүй байна.

6. Хуулийн төслийн 4.4 дэх заалт нь мөн хуулийн 30.5 дахь заалттай зөрчилдөж байна. 4.4 дэх заалтад “Шашин шүтлэгийн ялгаа, шашин шүтэх эс шүтэх байдлаас хамаарч бусдад давуу байдал олгох болон хязгаарлалт бий болгох, түүнчлэн аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно” гэсэн атлаа хуулийн төслийн 30.5-д “Шашны байгууллага бичгээр зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд түүний байр талбай, эзэмшлийн газарт бусад шашны байгууллагаас шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж хязгаарлалт тогтоожээ. Энэ хоёр заалт хоорондоо зөрчилтэй төдийгүй шашин шүтэх эрх чөлөөний тухай гэдэг хуулийн үндсэн зарчимтай зөрчилдөж байна.

Ямар шашин сурталчилж байгаагаас үл хамаарч шашны байгууллагууд бүгд эрх зүйн этгээд бөгөөд хуулийн өмнө тэгш эрхтэй. Тиймээс шашны байгууллагын хуулийн дагуу явуулж буй шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагааг нөгөө шашны байгууллага нь “бичгээр өгөх зөвшөөрлөөр” хязгаарлах эрхгүй юм.

7. Хуулийн төслийн 4.7-д “иргэнийг...албадах, дарамтлах, заналхийлэхийг хориглоно” гэсэн хэлбэр төдий заалт байна. Иргэний хүсэл зоргийн эсрэг аливаа үйлдэл хийхийг албадах, дарамтлах, заналхийлэх нь эрүүгийн болон зөрчлийн хуулиар хориотой үйлдэл. Иргэнийг шашны үйл ажиллагаанд оролцуулахаар нөлөөлөх нөлөөллийг илүү өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай. Жишээлбэл, орон гэрээр нь очих, спорт, соёл, урлагын арга хэмжээгээр халхавчлан шашны үйл ажиллагаа явуулах, үзэл номлолоо хүчээр тулгах, шахалт үзүүлэх, ядуурал, гачигдлыг ашиглан хөрөнгө мөнгөөр татах, хууран мэхлэх, ойр дотны хүмүүсээр нь дамжуулан ятгах, нөлөөлөх, сэтгэл санааг нь үймүүлэх гэх мэт...

Ерөөсөө шашин шүтэх, эс шүтэх болон шүтэх шашнаа хүн өөрөө сонгох эрхтэй байхад ухуулга ятгалгаар шүтүүлэх, шашин дэлгэрүүлэх нь хүний эрхийг зөрчиж буй үйлдэл юм. Иймд Монгол улсын иргэдийн уламжлалт шашныг өөрчлүүлэхээр ятгах, орон гэрээр нь ухуулга сурталчилгаа зохион байгуулах, итгэл үнэмшилд нь амь зуулга, санхүүгийн аргаар нөлөөлөхийг хориглох нь зүйтэй.

8. Хуулийн төслийн 4.8-ын “Наминчлалын нууц нь хуулиар хамгаалагдана” гэсэн заалт нь мөн хуулийн төслийн 4.5-д заасан “Иргэн шашин шүтлэгийн ялгаанаас үл хамааран хуулийн өмнө тэгш эрхтэй байна” гэсэн заалттай зөрчилдөнө. Тэгээд ч “наминчлал” гэдэг нь бүх шашинд байдаг зан үйл биш. Тухайлбал, Монгол Улсад зонхилох байр суурьтай байгаа буддын шашинд байхгүй. Тиймээс “наминчлал” хийдэг шашны байгууллагын номлол түгээгч нь бусад шашны шүтэгч болон шашин эс шүтэгчээс хууль бусаар давуу эрх эдлэх болж байна.

Энэ заалт Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж заасныг зөрчжээ.

Улмаар энэ заалт нь цаашдаа эрүүгийн гэмт хэргийг нуун дарагдуулах боломжийг бий болгоно. Шашны байгууллагын номлол түгээгчийн хуулийн хариуцлага хүлээхгүй байхаар заасан энэ давуу талыг зохион байгуулалттай гэмт бүлэглэл, гэмт хэрэгтнүүд ашиглахыг үгүйсгэхгүй юм. Жишээлбэл, Гэмт хэрэг үйлдсэн этгээд, гэмт хэргийн гэрчийг шашны байгууллагын номлол түгээгч болгоод түүнд наминчилснаар гэмт хэргийг нуун дарагдуулж чадна.

9. Хуулийн төслийн 4.9-д зааснаар “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний шашны бүлэг, шашны байгууллага байгуулах, шашны сургааль номлол дэлгэрүүлэх эрхэнд хязгаарлалт тогтооно” гэжээ. Гэхдээ эдгээр этгээдүүд шашны байгууллагын бусад үйл ажиллагаанд хэрхэн оролцох талаар зохицуулалтыг орхигдуулсан байна. Жишээлбэл, шашны үйлчилгээ үзүүлэх, гадаад харилцаа явуулах, шашны зан үйл, ёслол үйлдэх, шашны сургууль байгуулах, шашны хэвлэл мэдээллийн байгууллага байгуулах гэх мэт...

Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд заасан “иргэн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй” гэдэг заалт нь зөвхөн Монгол Улсын иргэнд хамааралтай. Энэ эрхийг гадаадын иргэн, харьяалалгүй хүнд шууд болон шууд бусаар хамааруулж, тэднийг Монгол улсад шашны үйл ажиллагаа явуулахыг хуульчилж байгаа нь Үндсэн хуулийн дээрх заалттай зөрчилдөнө.

Тэгээд ч хуулийн төслийн 4.9 дэх заалт нь үндсэндээ ач холбогдол багатай заалт болжээ. Учир нь яг дараагийн 4.10 дахь заалтаар “гадаадын иргэн, харьяалалгүй хүн шашны бүлэг байгууллагад гишүүнээр элсэх, үйл ажиллагаанд оролцох, шашны байгууллагад хөдөлмөр эрхлэх эрхтэй” байхаар тусгажээ. Өөрөөр хэлбэл, 4.9-д заасан хязгаарлалтыг тойрч гарсан заалт болжээ.

10. Хуулийн төслийн 5.1-д зааснаар шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө хүүхдэд хамаарч байна. Хуулийн төсөлд “хүүхэд” гэсэн нэр томъёог тайлбарлаагүй, тодорхойлолт хийгээгүй, насны хязгаарлалтыг зааж өгөөгүй байна. Харин хуулийн төслийн 5.2-т “бага насны хүүхэд” гэж заагаад дараагийн 5.3 дахь заалтаар тайлбар хийхдээ “бага насны” хүүхэд гэдгийг 14 насанд хүрээгүй хүүхэд гэж тайлбарлажээ. Хуулийн төслийн 5.1-д заасан “хүүхэд” гэдэг хоёр нэр томъёог зайлшгүй тайлбарлах шаардлагатай. Тайлбарлаж ялгааг гаргахгүй бол маргаан үүсгэж, улмаар төр, шашны байгууллага, эцэг, эхийн хооронд ноцтой үр дагавартай маргаан, зөрчил үүсгэх болно.

11. Хуулийн төслийн “Хүүхдийн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй байх эрх” гэсэн 5 дугаар зүйл нь анхаарал татаж байна. Тухайлбал, хуулийн төслийн 5.2 дахь заалт. Энэ заалтаар “Бага насны буюу 14 нас хүрээгүй хүүхдийг шашны бүлэг, шашны байгууллагын гишүүнчлэлд элсүүлэх, татан оролцуулах, хүүхдийн хүсэл зоргийг эсрэг болон эцэг, эх асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр шашны сургуульд элсүүлэх, шашны сургалтанд хамруулах, шашны үйл ажиллагаа болон шашны бүлэг, шашны байгууллагаас зохион байгуулж буй бусад арга хэмжээнд оролцуулахыг хориглоно” гэжээ.

Энэ заалт нь Бурханы шашин шүтэгч буддистуудад илүү хамаарах, тэдний үйл ажиллагааг хязгаарласан, шашин шүтэх эрхэд хохирол учруулах заалт болжээ. Учир нь Бурханы шашин нь өөрийн онцлогтой. Хүүхдийг бага наснаас нь сургадаг, олон жилийн урт хугацааны сургалттай байдаг. Мөн бурханы шашины хутагт, хувилгаад бага насандаа тодорч, бурханы ном сургаалийг бага наснаас судалж, шашны үйл ажиллагаа, шашны бусад арга хэмжээнд оролцдог. Энэ нь Бурханы шашны олон зуун жилийн түүхэнд мөрдөгдөж байгаа зан үйл, ёс заншил юм.

Монголын нутаг дэвсгэрт Бурханы шашин дэлгэрээд 2000 гаруй жил болж байгаа бөгөөд 3 удаа дэлгэрсэн гэж үздэг. Эхнийх нь нэн эртний үе, хоёрдахь нь 13 дугаар зууны Их хаадын үе, 3 дугаар дэлгэрэлтийг хожуу үе гэдэг бөгөөд 16 дугаар зуунаас дэлгэрсэн байдаг. Бурханы шашин нь Монгол Улсын иргэдийн зонхилох хэсэг нь шүтдэг шашин билээ. Гэтэл Хуулийн төслийн энэ заалт нь Монголын соёл, уламжлалыг тээгч олон зуун жилийн түүхтэй бурханы шашны онцлогыг үл харгалзан Монгол улсын буддистуудын шашин шүтэх эрх чөлөөг хязгаарласан, ялгаварласан зохицуулалт болжээ.

Учир нь энэ заалт Монголын буддистуудын хувьд маш чухал 10 дугаар Богдтой холбогдож байна. Богдын 10 дугаар дүр дахин төрөх нь бурханы шашны том соёл, уламжлал бөгөөд бурханы шашны хутагт хувилгаадыг багад нь тодруулдаг уламжлал, ёс заншилтай. Гэтэл энэ хуулийн төслийн 5.2 дахь заалт нь Монголын бурханы шашны Тэргүүн 10 дугаар Богдыг 14 нас хүртэл нь дахин тодруулж, ширээнд нь залахыг шууд хориглосон заалт болжээ.

Өөрөөр хэлбэл, 10 дугаар Богдыг 14 насанд хүрсний дараа түүнийг тодруулж болох заалт байна. Гэтэл одоо бага настай түүнийг 14 нас хүрэх үед дэлхийн бурханы шашны нөхцөл байдал маш өөр болсон байх бөгөөд бурханы шашны төв болохоор өрсөлдөж байгаа улс орнууд энэ хугацаанд давуу байдал олж авах болно. Хуулийн төслийн энэ заалт нь тэдгээр улс орнуудад давуу байдал олж авах цаг хугацааны боломжийг олгосон, бурханы шашны талаар явуулж буй гадаад улсын бодлогыг хэрэгжүүлэх, тэдний эрх ашигт үйлчилсэн заалт гэх хардлага төрүүлж байна.

12. Хуулийн төслийн 6 дугаар зүйл нь “Төр, шашны бүлэг, шашны байгууллага хоорондын харилцаа” гэсэн Үндсэн хуулийн Есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна” гэсэнтэй зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд зааснаар төр нь сүм, хийдтэй л харилцана, хуулийн этгээдийн эрхгүй шашны бүлэгтэй биш.

Учир нь хуулийн төслийн 7.1-д “шашны бүлэг нь хуулийн этгээдийн эрхгүй байгууллага” гэсэн атлаа төртэй харилцах гэсэн ойлгомжгүй байна. Хуулийн этгээдийн эрхгүй шашны бүлэг гэх байгууллагатай төр харилцаа үүсгэх эрх зүйн үндэслэлгүй.

13. Хуулийн төслийн 6.1 -д “Төр нь шашнаа хүндэтгэх, шашин нь төрөө дээдлэх зарчимд үндэслэнэ” гээд мөн хуулийн 6.2-т тухайн зарчмыг тусгажээ.

“Төр нь шашнаа хүндэтгэх, шашин нь төрөө дээдлэх” Үндсэн хуулийн Есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг энэхүү хуулийн төсөлд зарчим болгоод түүнийг тоочин заахыг оролджээ. Хэрэв ингэж зарчим тогтоож байгаа бол эхлээд Үндсэн хуулийн Есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ” гэсэн заалтыг тодорхой болгож хуульчлах ёстой. Түүний дараа иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хуульчлах нь оновчтой болно.

14. Хуулийн төслийн 6.2.1-д заасан "...аливаа нэг шашин, шашны урсгал, чиглэлийг төрийн, эсхүл албан ёсны шашин гэж тогтоохгүй байх" заалтыг олон улсын жишигтэй уялдуулан авч үзэх шаардлагатай.

АНУ-д төвтэй "Pew Research Centre" судалгааны төвөөс 2017 гүйцэтгэсэн судалгаагааны дүнгээс харахад дэлхийн 199 оны 43 улс (22%) төрийн шашинтай, 40 улс (20%) зонхилох шашинтай ("уламжлалт" эсвэл "түүхэн" гэсэн нэр томъёолоор хууль эрхийн бичгүүдэд нь томъёологдсон байдаг) байна. Дэлхийн 199 орноос 83 улс (42%) хуульчлагдсан төрийн шашинтай, эсвэл зонхилох шашинтай байна. Төрийн шашинтай улс орнуудын ихэнхи хувийг Исламын шашин (43 улс) харин зонхилох шашинтай улсуудын ихэнхи хувийг Христийн шашин (28 улс) эзэлж байна.

Харин 106 улс (53%) төрийн шашингүй бөгөөд аль нэг шашныг бусад шашнаас илүүтэйд авч үзэх бодлого баримтладаггүй бол 10 улс (5%) шашны талаар эсрэг бодлого баримтлаж байна.

Төрийн шашинтай улсуудын 10 улсын 8 (86%) нь төрөөс шашны боловсролыг дэмжин санхүүжүүлдэг, 51% нь шашны сүм хийдүүд байгуулах, засварлах ажилд санхүүгийн тусламж үзүүлдэг байна. Харин зонхилох шашинтай улсуудын 3 улсын 1 (33%) нь шашны сүм хийд байгуулах, засварлах ажилд санхүүгийн тусламж үзүүлдэг, 45% нь эргэл мөргөл хийх, лам хуврагт цалин олгох зэргээр санхүүжүүлэлт хийдэг байна.

Төрийн буюу зонхилох шашинтай улсуудын шашин Монгол Улсад нэвтэрснээр төрийн бодлогоор шашнаа дэмждэг тухайн улс орнуудын Засгийн газар Монгол Улсад өөрийн шашныг дэмжсэн улс төр, эдийн засгийн бодлого баримтлах болно. Энэ нь Монгол Улстай харилцах харилцаанд нөлөө үзүүлэх болно гэдгийг зайлшгүй анхаарах ёстой.

15. Хуулийн төслийн 6.2.2 "төрт ёс, үндэсний эв нэгдэл, түүх соёлын уламжлалыг нандигнан өвлөх үүднээс буддын шашины зонхилох байр суурийг хүндэтгэнэ" гэсэн нь Үндсэн хуулийн Үндсэн хуулийн Есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалт, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг давтсан заалт байна.

Үндсэн хуулийн дээрх заалтад үндэслэн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг боловсруулан 2010 онд УИХ-аар баталжээ. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын "Соёл иргэншлийн аюулгүй байдал" гэсэн 3.1.4-ийн 3.1.4.8-д "Уламжлалт Бурханы шашин, соёлыг сэргээн хөгжүүлж, сүм хийдийн үйл ажиллагааг нийгмийн оюун санааг гэгээрүүлэх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, ядуурлыг бууруулах, зовлон гамшигт нэрвэгдсэн хүн ардад туслалцаа үзүүлэх, байгаль орчныг хамгаалах үйлсэнд чиглүүлэхэд төрөөс анхаарч, дэмжлэг үзүүлнэ", мөн 3.1.4.9-д "Монголын ард түмний олон зуун жилийн оюуны өвийг тээж, хадгалж ирсэн Монголын Бурханы шашны өв соёлын судалгааг төрөөс онцлон дэмжинэ" гэж тус тус зааж уламжлалт бурханы шашин, түүний өв соёлыг Монгол Улсын соёл иргэншлийн аюулгүй байдалтай холбоотой авч үзсэн байдаг.

Гэтэл эдгээр заалтын үзэл санааг дэмжсэн заалт энэхүү хуулийн төсөлд байхгүй байна.

Хуулийн төслийн 37.1.2-т "шашны байгууллагын өмчлөл, эзэмшилд байгаа түүх, соёлын дурсгалт барилга байгууламж, хөшөө дурсгал, бусад түүх, соёлын дурсгалт

зүйлийг хадгалах, хамгаалах, сэргээн засах үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлнэ” гэж Бурханы шашны өв соёлын судалгааг төрөөс анхаарах дэмжлэг үзүүлэх асуудалд бусад шашны урсгалыг хамруулсны зэрэгцээ төрөөс үзүүлэх дэмжлэг туслалцааны зориулалтыг өөрчилсөн байна.

Мөн хуулийн төслийн 6 зүйлийн 6.2.1- т “...аливаа нэг шашин, шашны урсгал, чиглэлийг төрийн, эсхүл албан ёсны шашин гэж тогтоохгүй байх, мөн 6.2.2- т “төрт ёс, үндэсний эв нэгдэл, түүх соёлын уламжлалыг нандигнан өвлөх үүднээс буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэнэ” гэсэн нь агуулгын хувьд зөрчилтэй байна.

Улмаар “буддын шашны зонхилох байр суурийг” гэдэг ойлголт нь мөн хуулийн 6.2.1 дахь заалттай зөрчил үүсгэх болно. Ингэснээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа уламжлалт буддын шашинаас бусад шашин “зонхилох” гэдэг үгийг тайлбарлах шаардлагыг төрд тавихыг үгүйсгэхгүй.

16. Хуулийн төслийн 6.2.3 дахь заалтаар иргэний шашин шүтлэгийн байр суурийг бүртгэхийг хоригложээ. Төр өөрийн иргэний шашин шүтлэгийн байр суурь, үзэл бодлогыг бүртгэхийг хориглож болохгүй. Энэ нь зөвхөн статистик бүртгэлтэй холбоотой асуудал болохоос иргэний шашин шүтэх эрх чөлөөтэй холбоотой, түүнийг хязгаарласан хэрэг биш. Тухайн иргэний шашин шүтлэгийг мэдээгүйгээс төрийн зүгээс түүний эрхийг хязгаарласан үйлдэл хийгдэхийг үгүйсгэхгүй.

Нөгөө талаасаа энэ заалтыг ашиглаж шашны бүлэглэл, байгууллага өөрсдийн гишүүдийг нууцлах боломжтой болно. Монгол Улс иргэний шашин шүтэх эрх чөлөөтэй гэж Үндсэн хуулиндаа заасан байхад шашин шүтэгчид өөрсдийгөө төрд бүртгүүлэхгүй нууцлах шаардлагагүй юм.

Одоо мөрдөгдөж байгаа Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт ийм зохицуулалт байгаа бөгөөд энэ нь “... уг хүн өөрөө хүссэнээс бусад тохиолдолд” гэсэн уян хатан зохицуулалт байгаа болно.

17. Хуулийн төслийн 6.2.4-т дахин “хүүхэд” гэдэг субъект орж ирж байгаа бөгөөд хүүхдийн шашин шүтэх эрхийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар хязгаарлахгүй байхаар заасан нь хуулийн төслийн 5.2 “Бага насны буюу 14 нас хүрээгүй хүүхдийг шашны бүлэг, шашны байгууллагыг гишүүнчлэлд элсүүлэх, татан оролцуулах, хүүхдийн хүсэл зоргийг эсрэг болон эцэг, эх асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр шашны сургуульд элсүүлэх, шашны сургалтанд хамруулах, шашны үйл ажиллагаа болон шашны бүлэг, шашны байгууллагаас зохион байгуулж буй бусад арга хэмжээнд оролцуулахыг хориглоно” гэж заасантай зөрчилдөөн үүсгэж байна.

Үүнээс харахад “хүүхэд”, “бага насны хүүхэд” гэсэн нэр томъёог маш тодорхой болгохгүй бол энэ хоёр хүүхдийн шашин шүтэх эрх чөлөөний тухай ялгаатай ойлголтыг бий болгож байна.

18. Хуулийн төслийн 6.2.7-д байгаа “зөвлөн зохицуулах”, “шаардлагатай бол зогсоох” гэсэн төрд эрх олгосон заалтыг тодорхой тайлбарласан нэр томъёоны тодорхойлолт хийх шаардлагатай. Ялангуяа зогсоох “шаардлага”-ыг маш тодорхой зааж өгөх ёстой.

19. Хуулийн төслийн 6.3-т төрийн байгууллага, төрийн албан тушаалтан нь зөвхөн шашны бүлэглэл, байгууллага, гадаад улсын шашны байгууллагаас хандив, эд материалын дэмжлэг авахыг хориглосон болохоос гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнээс хандив, дэмжлэг авахыг хориглоогүй байна.



Өөрөөр хэлбэл, гадаад, дотоодын шашны бүлэглэл, байгууллагын гишүүн иргэн хувь хүнийхээ хувьд төрийн байгууллага, албан тушаалтанд хандив дэмжлэг өгч болохоор байна.

20. Хуулийн төслийн 6.5 дахь заалтаар шашны бүлэглэл, байгууллагын гишүүн улс төрийн үйл ажиллагааг явуулах эрхийг баталгаажуулсан байна.

Энэ тохиолдолд шашны бүлэглэл, байгууллагын гишүүн нь улс төрийн үйл ажиллагаа явуулахдаа өөрийн гишүүнчлэл бүхий шашны бүлэг, шашны байгууллагын үйл ажиллагааг дэмжихгүй, давуу байдал үүсгэхгүй байх үүргийг мөн хуулиар хүлээлгэх нь зүйтэй. Төрийн албан хаагч аливаа нэг шашны байгууллагын удирдах, ТУЗ-ын гишүүн байхыг хориглох заалт оруулах нь зүйтэй. Гэтэл ийм зохицуулалт хуулийн төсөлд байхгүй байна.

Төр аливаа иргэний шашны байр суурь, үзэл бодол, хандлагыг тодорхойлж бүртгэхгүй байхаар тусгасан 6.2.3 дахь заалт болон дээр дурьдсан 6.5 дахь заалтууд нь шашны бүлэглэл, байгууллага гишүүнээ нууцлах, гишүүнээрээ дамжуулан улс төрд нөлөөлөх зорилгоор зориуд оруулж байгаа заалтууд гэж үзэж байна.

21. Төрийн байгууллага шийдвэр гаргахдаа тухайн шашны бүлэг, байгууллагыг байр сууриа илэрхийлэх боломж олгох тухай хуулийн төслийн 6.6 дахь заалт нь хуульчлах шаардлагагүй холбогдох журмаар зохицуулж болох заалт. Ингэж хуульчлах бол тухайн шашны бүлэг, байгууллага өөрийн байр суурийг ямар хэлбэрээр илэрхийлэхийг тодорхой тусгах нь зүйтэй. Жишээлбэл, Олон нийтийг хамарсан жагсаал, цуглаан, суулт хийх нь байр сууриа илэрхийлэхэд хамаарах уу гэдгийг хуулийн төсөлд тодорхой тусгах ёстой.

Мөн байр сууриа илэрхийлэх тодорхой хугацаа тогтоож өгөхгүй бол байр сууриа илэрхийлэхгүй байгаад байвал төр шийдвэр гаргах боломжгүй хүлээх байдал үүсэхээр байна.

22. Хуулийн төслийн 7 дугаар зүйл бүхэлдээ зориулагдсан “шашны бүлэг” хэмээн өмнө нь Монгол Улсад байгаагүй шашны зохион байгуулалтын тухай ойлголт орж иржээ. Хуулийн төсөлд шашны бүлэг байгуулах иргэдийн тоог заагаагүй байна. Мөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн гишүүн байж болохоор заажээ. Одоо мөрдөгдөж байгаа Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт байгаа “...Шашныг гадаадаас зохион байгуулалттайгаар нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн чухал ач холбогдолтой заалт байгааг энэ хуулийн төсөлд орхигдуулжээ.

Хуулийн төслийн 7.3-т “шашны бүлгийн байр, эд хөрөнгө нь зөвхөн гишүүдээс олгогдсон байх” гэж зааснаар уг бүлгийн гишүүн болсон гадаадын иргэн, харьяалалгүй хүнээс ямар ч хэлбэрээр санхүүжилт авах боломжийг нээсэн байна. Тиймээс энэ заалтад байгаа бусад этгээдээс хандив, дэмжлэг, тусламж авахыг хориглосон заалт үр дүнгүй. Сонирхсон этгээд шашны бүлгийн гишүүнээр элсээд л уг бүлэгтээ аливаа хэлбэрийн санхүүжилт өгөх эрхтэй болохоор байна.

Энэ заалт нь гадаадын шашны урсгалыг хөхиүлэн дэмжиж, тэдгээр урсгалууд манай улсад өргөжин бэхжихэд илт хүргэх бөгөөд гадаадын иргэд шашны бүлгийг Монгол улсын нутаг дэвсгэрт олноор байгуулж, шашнаараа дамжуулж манай улсын улс төр, нийгэм, эдийн засгийн байдалд ил, далдаар нөлөөлөх сүлжээ үүсгэн ажиллах боломжийг олгожээ. Улмаар улс орны аюулгүй байдал эрсдэл учирна.

Энэхүү шашны бүлэг гэгч нь засаг захиргааны хамгийн доод шашны нэгжид үйл ажиллагаа явуулж шашин дэлгэрүүлэхээр байгуулагддаг нэгж бөгөөд хэрэв үүнийг хуульчилбал богино хугацаанд газар авч төслийн 8.3-д заасны дагуу "орон нутгийн шашны байгууллага (сүм) 8.4-т заасан дагуу төвлөрсөн шашны байгууллага болон шат ахин бүтэц, сүлжээ нь томорч эрчимжих болно.

23. Шашны бүлэг нь хуулийн этгээдийг эрхгүй атлаа байгуулагдсан тухайгаа мэдэгдэх мэдэгдэл гаргах, шашны урсгал, чиглэл, гол сургаал, номлол, бүлгийн гишүүдийн овог нэр, оршин суугаа хаяг байршил зэрэг мэдээллийг тусгай маягтын дагуу гаргах ажээ. Мөн 2 жил тутам тайлан гаргаж харьяа сум, дүүргийн ЗДТГ-т хүргүүлэх зэрэг уялдаа холбоогүй, ойлгомжгүй заалтууд хуулийн төсөлд байна.

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага тул төрийн байгууллагатай хуулийн хүрээнд шашны бүлэг гэдэг байгууллагын өмнөөс харилцах эрх зүйн үндэслэлгүй. Тэгээд ч шашны урсгал, чиглэл, гол сургаал, номлол, бүлгийн гишүүдийн овог нэр, оршин суугаа хаяг байршил зэрэг мэдээллийг төрийн байгууллагад гаргаж өгөх тухай 7.5, 7.6, 7.7, 7.11 заалтууд нь мөн хуулийн төслийн төр, иргэний шашин шүтлэгийн байр суурь, үзэл бодлогыг бүртгэхийг хориглосон хуулийн 6.2.3 дахь заалттай зөрчилдөж байна.

Хуулийн төсөлд тусгаснаар шашны бүлэглэл хуулийн этгээдийн эрхгүй учир тайлан гаргах боломжгүй, тиймээс шашны бүлэглэлийг бүрдүүлж буй иргэн/гишүүн тус бүрдээ тайлан гаргах уу гэх мэт ойлгомжгүй зохицуулалт хуулийн төслийн 7.6-д байна.

Шашны бүлэг хуулийн этгээдийн эрхгүй байна гэсэн нь ямар нэг хариуцлага хүлээхгүй гэдэг санааг давхар агуулжээ.

24. Хуулийн төслийн 7.8 дахь заалтаар шашны бүлэг шашны зан үйл, ёслол үйлдэх, шашны болон шашны ёс зүйн сургалтыг явуулахдаа зөвхөн бүлгийн гишүүдийг оролцуулах эрхтэй гэсэн нь далд, нууц байгууллага болох боломжийг нээн өгч байна. Өөрөөр хэлбэл, шашинаар халхавчилсан зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл бий болох боломжтой. Мөн барууны улс орнуудад байдаг зөвхөн гишүүнчлэлтэй үйл ажиллагаа явуулдаг "нууц нийгэмлэг"-үүд үүсэх нөхцлийг бүрдүүлэх болно.

25 Хуулийн төслийн 8 дугаар зүйлд шашны байгууллагын үйл ажиллагааны зохицуулалтыг тусгасан байна. Шашны байгууллагыг орон нутгийн болон төвлөрсөн гэж ангилснаар орон нутаг болон төвлөрсөн суурин газарт үйл ажиллагаа явуулж болохыг хуульчилжээ.

Орон нутагт шашны байгууллага байгуулах нь маш хялбар байхаар зохицуулжээ. Хуулийн төслийн 8.3-т зааснаар 18 насанд хүрсэн 10 иргэн орон нутгийн шашны байгууллагыг байгуулж байгаа, мөн хуулийн төслийн 8.4-т зааснаар 10-аас доошгүй орон нутгийн шашны байгууллага нэгдэж төвлөрсөн шашны байгууллага байгуулж байгаа нь хэт хялбар байна. Өөрөөр хэлбэл 18 насанд хүрсэн 100 иргэн төвлөрсөн шашны байгууллага байгуулж байна. Насны хувьд шашны сургаалийн мөн чанарыг 18 насанд ойлгож, сурсан байх нь залуудах нас юм. Нийгмийн оюун санаанд чухал нөлөө бүхий шашны байгууллагыг байгуулахдаа төлөвшөөгүй, залуусыг ашиглахаар ийнхүү нас, тоог сонгожээ.

Шашны бүлэг байгуулах, орон нутгийн шашны байгууллага байгуулах, хуулийн этгээдийн эрхгүй шашны бүлэг, харьяалалгүй иргэн шашны үйл ажиллагаа явуулах, 10 аас доошгүй хүн сайн дурын үндсэн дээр орон нутгийн шашны байгууллагыг байгуулах, шашны бүлэг, шашны байгууллага байгуулах эрхийг нь орон нутгийн засаг

захиргааны байгууллагад өгсөн зэрэг заалтууд нь үндэсний аюулгүй байдалд харш, үндэсний язгуур ашиг сонирхолын нэг болох үндэстний нэгдмэл байдлыг алдагдуулж, монголчуудыг хэт жижиглэсэн хагалган бутархах далд үзэл санаа агуулж байж болох талтай байна.

Тэгээд ч төслийн 8.7-д заасан дагуу “орон нутгийн байгууллага нь энэ хуулийн 11.1-д заасны дагуу олгосон зөвшөөрөлд тодорхойлсон нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулах” эрхтэй болох ажээ. Харин орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын зүгээс үйл ажиллагаанд нь тавих хяналтын тухай заалт хуулийн төсөлд тусгагдсангүй.

26. Шашны байгууллага нь дүрэм болон дотоод журамдаа үйл ажиллагаагаа тусган явуулах эрхтэй байхаар заасан бөгөөд уг дүрэм, журамд тавих шаардлагыг хуулийн төсөлд тусгаагүй байгаа нь дүрэм, дотоод журамдаа заасан л бол шашны байгууллага маш өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулж болохоор байна.

27. Хуулийн төслийн 9.4 дэх заалтаар Монгол Улсад бүртгэгдсэнээс хойш 50 жил үйл ажиллагаа явуулаад тухайн шашны байгууллага нэрэндээ МОНГОЛ, МОНГОЛЫН, ҮНДЭСНИЙ, НИЙТИЙН, НЭГДСЭН зэрэг үгийг ашиглах эрхтэй гэсэн нь тухайн шашны байгууллагыг МОНГОЛЫН шашин хэмээн албан ёсоор хүлээн зөвшөөрөх нөхцлийг хуульчилжээ. Өөрөөр хэлбэл, Энэ хуулиар Монголын төр анх удаа цаашдаа “монголын”, “үндэсний”, “нийтийн” гэсэн шашин бий болох нөхцлийг албан ёсоор хуульчилж байна. Энэ заалт ноцтой үр дагаварт хүргэнэ.

Тэгээд ч эдгээр үгсийг тус тусад нь хэрэглэх үү, хамтад нь хэрэглэх үү гэдгийг тодорхой зааж өгөөгүйгээс МОНГОЛ ҮНДЭСНИЙ, МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ, МОНГОЛЫН НИЙТИЙН ҮНДЭСНИЙ, НЭГДСЭН МОНГОЛ ҮНДЭСНИЙ, НИЙТИЙН НЭГДСЭН МОНГОЛЫН, НИЙТИЙН НЭГДСЭН МОНГОЛ ҮНДЭСНИЙ, МОНГОЛЫН НИЙТИЙН, НИЙТИЙН НЭГДСЭН гэх мэтээр холбон хэрэглэж болохоор байна.

Монгол Улсад 50 жил болсон аль ч шашин өөрийгөө монголын, үндэсний, нийтийн гэж нэрлэх хууль ёсны эрхийг нээж өгснөөр шашин хоорондын зөрчил, тэмцэл эхлэх болно. Монголын нийгэм шашны хуваагдалд орж, 2000 зуун жилийн түүхтэй Бурханы шашины зонхилох байр суурь албан ёсоор алдагдана. Буддын шашныг Монголын уламжлалт шашин гэдэг ойлголтыг байхгүй болгох далд санаатай оруулсан заалт гэж дүгнэж байна. Ийм заалт оруулснаар уламжлалт бурханы шашин, гаднаас нэвтэрсэн бусад шашны хооронд ялгаа байхгүй хэмээн хуульчилж буй хэрэг юм. .

Тэгээд ч хуулийн төслийн 6 зүйлийн 6.2.1- т “...аливаа нэг шашин, шашны урсгал, чиглэлийг төрийн, эсхүл албан ёсны шашин гэж тогтоохгүй байх” заалттай уялдлуулан авч үзвэл “Монгол улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэж үзнэ” гэсэн үзэл баримтлалд халдаж бусад шашны байр суурийг Монгол улсад бататган бэхжүүлж, буддын шашинтай нэг түвшинд тавих, түүний зонхилох байр суурийг саармагжуулах зорилготой гэж үзэж байна.

28. Хуулийн төслийн 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйлд шашны байгууллага байгуулах, түүнийг улсын бүртгэлд бүртгүүлэх зөвшөөрөл олгох зохицуулалтыг тусгажээ. Энэ зүйлд зааснаар заасан шашны байгууллагыг үүсгэн байгуулах заалт нь хэт хялбар, ердөө хурлын шийдвэр, дүрэм, иргэний үнэмлэхийн хуулбар, оршин суух хаягийн мэдээлэл, шашны байгууллагын оноосон нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар гэсэн ердийн бичиг баримтыг бүрдүүлж байна. Шашны байгууллага байгуулж байгаа иргэдэд сэтгэцийн, гадаадын давхар иргэншилтэй эсэх, ямар нэгэн хортой зуршилтай эсэхийг шалган тогтоох зэрэг тусгай шаардлага тавигдахгүй байна.

Мөн хуулийн төслөөр одоо мөрдөгдөж байгаа Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасан “Лам санваартан нарын үнэмлэхүй тоо, сүм хийдийн байршлыг төрөөс хянан зохицуулна” гэсэн хязгааралтыг байхгүй болгосон байна.

29. Хуулийн төслийн хамгийн их анхаарал татсан нэг заалт нь 11.2.4 болно. Энд зааснаар орон нутгийн шашны байгууллага нь үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр, хүн амын талаархи мэдээллийг өөрсдөө тодорхойлж байна. Ингэснээр шашны байгууллага үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрээ өөрсдөө дур мэдэн хязгаарлалтгүйгээр тогтоож болохоор болжээ. Шашны байгууллагууд ингэж үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрээ дур мэдэн тогтоосноор үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр нь давхцах магадлалтай. Улмаар тэдны хооронд үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн маргаан үүсч, зөрчил, тэмцэл болон өргөжих эрсдэлтэй заалт болжээ. Ийм утгатай заалт хуулийн төслийн 23.6-д мөн давтагдаж байна.

Уламжлалт Бурхан шашны ёсонд хүсч гуйсан хүнд ном тавьдаг, хүсээгүй хүнд ном тавьдаггүй зарчим нь Буддын шашныхан бусад шашныхантай шашны сургаалыг ухуулан дэлгэрүүлэх талаар өрсөлдөхөд тэнцвэргүй байдлыг бий болгодог. Шашны бүх байгууллага үйл ажиллагаагаа зөвхөн сүм, хийд дээр нь төвлөрүүлж явуулдаг зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна.

30. Хуулийн төслийн 11.5 болон 11.6-д зааснаар шашны байгууллагыг бүртгэхдээ Шашны асуудал эрхэлсэн зөвлөл (ШАЭЗ) 60 хоногт шийдэх бөгөөд мөн 60 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно гэжээ. Сунгахдаа “нэг удаа” хэмээн заасан учир цаашид сунгахгүй зөвшөөрөл олгохоор зохицуулагджээ. өөрөөр хэлбэл дээд тал нь 120 хоногоос илүү хугацаагаар хянах боломжгүй байхаар хуульчилжээ.

31. Хуулийн төслийн 12 дугаар зүйлд зааснаар шашны байгууллагыг үүсгэн байгуулагч нь субъект, түүнд хориглох зүйлийг хуульчилсан байна. Гэвч үүсгэн байгуулагч нь тухайн шашны шүтэгч байх шаардлага тусгагдаагүй байна.

Шашны байгууллагын үүсгэн байгуулагч байхыг хориглосон 12.3.1, 12.3.2, 12.3.3 гэсэн гурван заалт нь шаардлага хангахгүй байна. Хуулийн төслийн 12.3.2-д заасан эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдсэн байх нь иргэний шашин шүтэх эрхийг хязгаарлах хязгаарлалт болохгүй. Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 15-д заасан шашин шүтэх эрх чөлөөтэй зөрчилдөнө.

32. Орон нутгийн шашны байгууллагыг байгуулах зохицуулалт үүсгэн байгуулах гишүүдийн нас, тооны талаар зохицуулалттай бол төвлөрсөн шашны байгууллагыг байгуулах зохицуулалт ойлгомжгүй байна. Хуулийн төслийн 8.4-т зааснаар орон нутгийн 10-аас доошгүй шашны байгууллага төвлөрсөн шашны байгууллага байгуулж болно гэж нэг хувилбарыг заасан бол хуулийн төслийн 12.1-д зааснаар бас нэг иргэн ч шашны байгууллага байгуулж болохоор зохицуулалт хийгджээ. Энэ хоёр зохицуулалт тус тусдаа уялдаа холбоогүй байна.

33. Мөн хуулийн төслийн 12.3.1 дэх заалтаар зөвхөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үүсгэн байгуулагч байхыг хориглосон байна. Энэ заалтад гадаад улсын хуулийн этгээд хамаарахгүй. Тиймээс гадаад улсын хуулийн этгээд үүсгэн байгуулагч байхыг энэ хуулиар хориглоогүй байна.

Харин хуулийн төслийн 4.10-т зааснаар нэгэнт байгуулагдсан шашны байгууллагад гадаадын иргэн хуулийн этгээд, харьяалалгүй хүн гишүүнээр элсэн үйл ажиллагаа явуулах эрх нь нээлттэй байна.

34. Хуулийн төслийн 12.4-т болон 12.6-д шашны байгууллагын Үүсгэн байгуулагч, хандив, дэмжлэг, тусламж өгсөн этгээдүүдтэй холбоотой заалтууд анхаарал татаж байна. Тухайлбал, шашны байгууллага үүсгэн байгуулагдсанаас хойш хандив тусламж, дэмжлэг өгсөн этгээд нь үүсгэн байгуулагчид тооцогдохгүй гэж заасан байх тул тэдгээр нь гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс байх болно. Учир нь эдгээр субъектүүд хуулийн төслийн 12.3.1 дэх заалтаар шашны байгууллагын үүсгэн байгуулагч байхад хориотой. Харин монгол улсын иргэд шашны байгууллагыг үүсгэн байгуулсны дараа гадаадын иргэн, харьяалалгүй хүн уг шашны байгуулагад хандив, дэмжлэг, тусламж өгөх боломжийг 12.4 дэх заалтаар нээсэн байна.

Учир нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн хандив, дэмжлэг, тусламж өгөхийг энэ хуулиар хориглоогүй байна. Хуулийн төслийн 27.2.8-д зааснаар зөвхөн гадаад улсын Засгийн газар, түүнээс санхүүждэг хуулийн этгээд, шашны байгууллагаас хандив авахыг хориглосон байна. Засгийн газраас санхүүждэг гэдэг нөхцөл нь хязгаарлалт болж байна. Хэрэв гадаад улсын хуулийн этгээд, шашны байгууллага Засгийн газраас санхүүждэггүй бол тэдгээрээс хандив авах боломжийг нээсэн заалт байна.

Мөн хуулийн төслийн 12.5-д “шашны байгууллага байгуулагдсны дараа хандив, тусламж, дэмжлэг өгсөн этгээдийн хөрөнгө тухайн шашны байгууллагын эд хөрөнгө болно” гэж заасан байна. Үүнтэй уялдуулаад хуулийн төслийн 12.6-д үүсгэн байгуулагч нь шашны байгууллагын эд хөрөнгийг өмчлөх эрхгүй гэж зааснаар үүсгэн байгуулагч Монгол улсын иргэд шашны байгууллагын өмчийг өмчлөх эрхгүй болж байна. Харин үүсгэн байгуулах нь хориотой учир үүсгэн байгуулсны дараа санхүүгийн дэмжлэг, хандив, тусламж өгсөн гадаадын улсын иргэн, харьяалалгүй хүмүүс шашны байгууллагын эд хөрөнгийг өмчлөгч байхыг зохицуулсан зохицуулалт болжээ. Энэ нь гадаадын иргэн, харьяалалтгүй хүн шашны байгууллагын эд хөрөнгийг өмчлөх эрхийг баталгаажуулж, зориуд тусгасан заалт гэж үзэж байна.

Монгол улсын иргэнийг ашиглаж шашны байгууллага үүсгэн байгуулаад, дараа нь гишүүнээр нь өөрсдөө ороод, санхүүгийн дэмжлэг тусламж үзүүлж, бий болсон шашны байгууллагын хөрөнгийг өөрсдөө өмчлөхөөр зохицуулсан байна. Ийнхүү зохицуулалт хийсэн нь гадаадын сонирхогч этгээдүүдийн захиалгатай хуулийн төсөл гэсэн эргэлзээг төрүүлж байна.

35. Хуулийн төслийн 15.1-д зааснаар шашны байгууллагын эрх барих байгууллага нь Удирдах зөвлөл байх бөгөөд мөн хуулийн төслийн 16.1-д зааснаар Удирдах зөвлөл нь хандивлагч, дэмжигч, тэдгээрийн төлөөллөөс бүрдэнэ гэжээ. Үүнээс харахад Үүсгэн байгуулагч болох Монгол улсын иргэн Удирдах зөвлөлөө томилох эрхгүй, харин Хандивлагч, Дэмжигч (гадаадын иргэн, харьяалалгүй хүн байж болно. Энэ хуулиар хориглоогүй) өөрсдөө эсвэл тэдгээрийн томилсон хэн нэгнээс Удирдах зөвлөл бүрдэж байна. Үүнээс харахад гадаадын иргэд шашны байгууллагын эд хөрөнгийг өмчлөх эрхтэй төдийгүй, Удирдах зөвлөлийг өөрсдөө болон өөрсдийн үзэмжээр бүрдүүлэх боломжтой байхаар Хуулийн төсөлд тусгасан нь гадаадын улсын сонирхол, захиалгатай заалт гэсэн хардлагыг улам баталж байна.

Хуулийн төслийн 16.3-т зааснаар Удирдах зөвлөл нь даргаа гишүүдээсээ сонгож, хуулийн төслийн 17.1-д зааснаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шашны байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах, жилийн төсөв батлах, гүйцэтгэх удирдлагыг томилох, санхүүгийн тайланг хэлэлцэх төдийгүй шашны байгууллагын удирдлагын болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй хяналтын байгууллагын томилох эрхтэй байна.

Монгол Улсад байгуулагдах шашны байгууллагын өмчийн, удирдлагын бүрэн эрхийг үүсгэн байгуулагч монгол улсын иргэн биш, шашны байгууллагын гишүүд ч биш харин Хандивлагч, Дэмжигч хэмээх “Үл мэдэгдэгч субъект” хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд зохицуулалт хийсэн байна.

36. Хуулийн төслийн 27.2.8-д гадаад улсын Засгийн газар, түүнээс санхүүждэг хуулийн этгээд, шашны байгууллагаас хандив авахыг шашны байгууллагад хориглосон байна. Энэ заалтаар зөвхөн гадаад улсын Засгийн газар буюу түүнээс санхүүждэг гэж хязгаарлаж, гадаад улсын бусад байгууллага, төрийн бус байгууллага, иргэн, харьяалалгүй хүнээс хандив авахыг хориглоогүй байна.

Мөн гадаадын ямар ч этгээдээс дэмжлэг, тусламж авахыг хориглоогүй байна. Өөрөөр хэлбэл, хандивыг хориглосон атлаа дэмжлэг, тусламжийг хориглоогүй байна. Иймээс гадаад улсын аливаа этгээдээс дэмжлэг, тусламж авахад хуулийн 27.2.8 дахь заалт үйлчилэхгүй.

Хандив, хандивлагч нарт хязгаарлалт тогтоосон атлаа шашны байгууллагын удирдах зөвлөлд ордог, өөрийн төлөөллийг томилох эрхтэй Дэмжигчтэй холбоотой зохицуулалт энэ хуульд байхгүй байгаа нь анхаарал татаж байна. Зориуд энэ субъектийг зохицуулалтгүй, чөлөөтэй үлдээж байна гэсэн эргэлзээ зүй ёсоор төрж байна.

37. Хуулийн төслийн 23 дугаар зүйлд шашны байгууллага нь салбар төлөөлөгчийн газартай байхаар зохицуулалт хийж, улмаар гадаад улсын шашны байгууллага нь салбар, төлөөлөгчийн байгууллагатай байх боломжийг хуулийн төслийн 23.8-д тусгасан байна. Ингэснээр шашны байгууллагыг гадаадын иргэн, харьяалалгүй хүн үүсгэн байгуулахыг хориглох заалт ач холбогдлоо алдаж байна.

Гадаад улсын шашны байгууллага орон нутгийн шашны байгууллагын нэгэн адил шаардлагаар үйл ажиллагаа явуулахаар хуулийн төслийн 23.8-д тусгажээ. Мөн шашны байгууллага хэдэн салбар, төлөөлөгчийн газар байгуулж болох тухай хязгаарлалт байхгүй байна.

Тэгээд ч гадаад улсын шашны байгууллагын салбар төлөөлөгчийн газрын бүртгэх тусгайлсан журам байхгүй, гадаадын иргэний асуудал эрхэлсэн байгууллага ердийн журмаар бүртгэхээр хуулийн төслийн 23.9-д заажээ.

38. Шашны байгууллагын татан буулгах зохицуулалтыг заасан 25.1.1-д “тухайн шашны байгууллага зорилгодоо хүрсэн” бол татан буулгана гэж заасан нь ойлгомжгүй байна. Шашны байгууллага тодорхой зорилго тавьж үйл ажиллагаа явуулахыг төр хянах эрхийг хуульчлах шаардлагатай.

39. Хуулийн төслийн “Шашны байгууллагад хориглох зүйлс” гэсэн 27 дугаар зүйлийн “Тайлбар” хэсэгт “харгис, хүмүүнлэг бус шашин” гэдгийг тодорхойлохдоо “алан хядах террорист үйл ажиллагаа”, “хэт даврах экстремист үйл ажиллагаа”-г оруулсан атлаа “салан тусгаарлах үзэл буюу сепратизм”-ыг орхигдуулсан байна. Үүнээс харахад салан тусгаарлах үйл ажиллагаанд уриалсан шашны байгууллагын үйл ажиллагааг энэ хуулиар зөвшөөрчээ ойлголт төрж байна.

40. Хуулийн төслийн 28.3-т “Шашны байгууллага нь иргэдийн хүсэлтээр эмнэлэг, сувилалын газар, хүүхдийн, ахмадын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газарт шашны зан үйл, ёслол ... үйлдэж болно” гэж заажээ. “Иргэдийн хүсэлт” гэдгийг маш тодорхой болгох нь зүйтэй. Хүсэлт гаргах иргэн тухайн

байгууллагын албан хаагч байх уу, хөндлөнгийн хэн ч хамгаагүй иргэн байх уу, тухайн шашны байгууллагын гишүүн байх уу, шашин шүтгэгч иргэн байх уу гэдгийг маш тодорхой зохицуулах шаардлагатай.

Хэрэв шашин эс шүтэгч иргэд шашны зан үйл, ёслол хийлгэхгүй гэсэн эсрэг хүсэлт гаргавал яах вэ ? гэдэг асуудлыг хуулийн төсөлд орхигдуулжээ.

Хуулийн төслийн 30.4 дэх заалт мөн адил ийм зохицуулалт шаардлагатай. Уг заалтаар иргэн (хуулийн төсөлд нэг тоон дээр заажээ) хүсэлт гаргаснаар иргэдийн орон сууцны байр, талбайд шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулах, шашны ном зохиол, сурталчилгааны бусад материал тарааж байна.

Тэгээд ч энэ хуулийн заалтыг шашны байгууллага өөрийн зорилгод ашиглахад хялбар заалт болжээ. Сонирхсон шашны байгууллага өөрсдийн санаачилга, нөлөөлөлөөр хэн нэгэн иргэнээр хүсэлт гаргуулахад л шашны үйл ажиллагааг явуулах боломж нээгдэж байна.

Одоо мөрдөгдөж байгаа Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт ийм төрлийн үйл ажиллагааг иргэний биш “сүсэгтний хүсэлтээр” явуулна гэж заасан нь оновчтой зохицуулалт юм.

41. Хуулийн төслийн 28.5-д “Хууль, цэргийн дүрэмд өөрөөр заагаагүй бол цэргийн албан хаагчид мөргөл үйлдэх, шашны бусад зан үйл, ёслол үйлдэж болно” гэж заасан нь утгаараа зөвшөөрсөн заалт болжээ. Хэрэв төрийн цэргийн байгууллагууд (Зэвсэгт хүчин, дотоодын цэрэг, хил хамгаалах, онцгой байдал) ямар нэгэн хориглосон, хязгаарласан заалт цэргийн дүрэмд оруулахгүй байхад л энэ заалтын дагуу төрийн цэргийн байгууллагад шашны мөргөл, ёслол, бусад зан үйл үйлдэж болохыг нээж өгчээ.

Ингэж зааснаар одоо мөрдөгдөж байгаа Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь заалт “Төрийн харьяалал бүхий сургууль, байгууллагуудад шашны сургалт, цугларалт зохион байгуулахыг хориглоно”, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Сүм хийд, санваартан нар бурхан тахилын зүйлс, ном судар бүтээх, шашны зан үйл үйлдэх, хурал ном хурах зэргээр сүсэгтэн олонд чөлөөтэй үйлчилнэ” гэж зөвхөн сүсэгтэнд үйлчлэхээр тодорхой заасан хязгаарлалтыг байхгүй болгожээ.

42. Хуулийн төслийн “Шашны ном зохиол, шашны зориулалттай эд зүйл” гэсэн 29 дүгээр зүйл, “Шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа” гэсэн 30 дугаар зүйлийн зохицуулалтыг харахад шашны байгууллага өөрийн үйл ажиллагааг явуулах зорилгоор нь үйлдвэрлэл явуулах, гадаад, дотоод худалдаа хийх эрхтэй, хэвлэл мэдээллийн байгууллага байгуулах эрхтэй байна. Энэ заалтаар шашны гэсэн тодотголтой маш өргөн хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрхтэй болжээ. Шашны байгууллага нь том хэмжээний Ажил олгогч болж байна. Ингэснээр нийгмийн бусад салбарт шууд бусаар нөлөө үзүүлэх болно.

Улмаар шашны байгууллагын үйлдвэрчний эвлэл байгуулагдах суурь үүсч, шашны байгууллага Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд шашнаас гадна бусад хэлбэрээр тогтоох нөлөөлөлийн эерэг, сөрөг талыг тооцох аргагүй юм.

43. Хуулийн төслийн 28.7 болон 31.3 дахь заалтуудыг харахад шашны байгууллагын төрийн боловсрол, соёл, урлагын байгууллагатай хамтран ажиллах сонирхлыг дэмжсэн төдийгүй тэдэнд тийм боломжийг нээж өгсөн заалтууд байна.

Төрийн байгууллагын албан байранд шашны зан үйл явуулж болохгүй гэсэн 28.2 дахь заалтыг тойрч гарах заалт болжээ. Энэ хоёр заалтын дагуу соёл, гэгээрлийн төсөл хөтөлбөр нэрийн дор төрийн байгууллагын дэмжлэгийг авах, хамтран ажиллах төдийгүй, шашны түүх соёл, өв уламжлалын сургалт соёл, урлагын арга хэмжээний хүрээнд соёл, урлагын байгууллагад мөргөлийн өрөө, тасалгаа байгуулах боломжтой болж байна.

Соёл урлаг нь нийтийн оюун санаанд нөлөөлөх нөлөөлөл өндөр байдаг учир шашны байгууллагууд соёл урлагыг далд хэлбэрээр ашиглах боломжийг нээж өгчээ.

44. Хуулийн төслийн 28.8-д “шашны байгууллагаас бусад этгээд ... суварга байгуулахыг хориглоно” гэж заасан нь бурханы шашинт буддист иргэдийн шашин чөлөөтэй шүтэх эрхийг хориглосон заалт болжээ. Нөгөө талаасаа Монгол Улсын иргэд хил орчмын бүс нутгийн аюулгүй байдлыг хангах үүднээс суврага босгож, маргаан гарсан үед өөрийн газар нутаг гэдгийг батлах чухал үндэслэл болдог. Энэ заалтаар энэхүү бичигдээгүй заншил хориглогдож байна.

45. Хуулийн төслийн “Шашны боловсролын байгууллага” гэсэн 32 дугаар зүйлд шашны байгууллага нь бага, бүрэн дунд боловсрол олгох сургуультай байх эрхтэй болж байна. Мөн 32.5 дахь заалтыг харахад шашны дээд боловсрол олгох дээд сургууль ч байх боломжтойгоор заажээ. Ингэснээр шашны бүх шатны сургууль нээгдэж сургалт явуулах боломжтой болох бөгөөд ямар нэгэн тусгай шалгуур тавигдаагүй байна.

Улмаар суралцагчийн хүсэлтээр гэрээр шашны боловсрол олгох заалт орж ирснээр шашны сургалтыг хязгаарлах боломжгүй, бүх өрх гэрт шашины номлол түгээгч орох боломжтой болжээ. Хуулийн төсөлд “Суралцагчийн хүсэлтээр” гэдэг хэлбэр төдий нөхцөл юм. Шашны номлол түгээгч санаачлан зохион байгуулж, суралцагчийг хүсэлт гаргахад нөлөөлж болно. Иймд зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн хүсэлт гаргавал гэх мэтчлэн хязгаарлалт байх нь зүйтэй.

46. Одоо мөрдөгдөж байгаа Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “Шашны байгууллага гадаад харилцааны асуудлаа эрх бүхий төрийн байгууллагатай зөвлөлдөн шийдвэрлэнэ” гэсэн байдаг бол энэ хуулийн төслөөр шашны байгууллага олон улсын, гадаад улсын байгууллага, хувь хүнтэй (гадаадын иргэн, харьяалалгүй хүн) хамтран ажиллах эрхтэй байхаар олон улсын хамтын ажиллагаа гэсэн 33 дугаар зүйлд заасан байна. Шашны байгууллагын гадаад харилцааг хяналтгүй, чөлөөтэй болгосон байна.

47. Хуулийн төслийн 34 дүгээр зүйлд шашны байгууллага өмчийн харилцааг зохицуулсан байна. Энэ зүйлд зааснаар шашны байгууллага өөрийн орлого, иргэн, байгууллагын хандив, өглөг, төрөөс шашны байгууллагад шилжүүлж өгсөн болон хуульд заасан бусад аргаар олж авсан, бий болгосон хөрөнгийг өмчлөх эрхтэй” болж байна.

Хуулийн төсөлд заасан “...хуульд заасан бусад аргаар” гэдэгт аж ахуйн үйл ажиллагааг зохицуулсан бусад хуульд заасан арга гэж ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, банкны тухай хууль, компанийн тухай хууль, концессын тухай хууль гэх мэт хуульд заасан аргаар хөрөнгө бий болгох маш өргөн боломжийг олгож, шашны байгууллага санхүүгийн хүчирхэг нөөц боломжийг үүсгэнэ. Энэ заалтыг баталгаажуулсан заалтыг хуулийн төслийн 35.4.4-т “шашны байгууллагын үйл ажиллагааны орлогод “хуульд нийцсэн бусад үйл ажиллагааны орлого хамаарна” хэмээн дахин тусгажээ. Ингэснээр шашны байгууллагын өрсөлдөх чадвар бусад



байгууллагатай харьцуулах аргагүй нэмэгдэж, улс орны эдийн засагт санхүүгийн тодорхой нөлөөлөл тогтоох боломжтой болно. Түүгээр дамжуулан улс төр, нийгмийн амьдралд шууд бусаар нөлөөлөх чадвартай болно.

Тэгээд ч шашны байгууллагын эд хөрөнгийн өмчлөгч нь Монгол Улсын иргэн биш хандивлагч, дэмжигч нар байх бөгөөд тэдгээр нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд байхаар хуульд зохицуулалт хийсэн байгаа болно.

Энэ хуулийн төслөөр Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Сүм хийд нь шашин-номын үйл ажиллагаа эрхлэн явуулах, ахуйн хэрэгцээгээ хангахад зайлшгүй шаардагдах аж ахуйг өмчийнхөө хүрээнд эрхэлж болно” гэсэн хязгаарлалтыг байхгүй болгожээ.

Хуулийн төслийн 34.3-т “Мөргөлийн зориулалттай хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг зээлдүүлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангах зорилгоор хураан авахыг хориглоно” гэсэн заалт нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш байна” гэснийг зөрчиж байна. Учир нь шашны байгууллагын эд хөрөнгийн өмчлөгч нь хандивлагч, дэмжигч нар болох бөгөөд тэдний өмчлөх эрх нь бусдаас давуу байж болохгүй.

48. Хуулийн төслийн 34.5 дахь заалт буюу татан буугдаж байгаа шашны байгууллагын өмчийг шилжүүлэх тухай заалт нь хэрэгжихэд хэцүү заалт юм. Учир нь шашны байгууллагын эд хөрөнгийг өмчлөгч болох хандивлагч, дэмжигч нь өмчөө ямар нэгэн хэлбэрээр бусдад шилжүүлэхийг зөвшөөрөхгүй бол хэрэгжихгүй.

49. Шашны байгууллагын аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх хязгаарлалтыг тогтоогоогүй байна. Ингэснээр компанийн адил аж ахуйн бүх төрлийн үйл ажиллагаа эрхлэх боломжтой болж зах зээлд шашны үзэл суртал, өөрийн шүтэгч гэсэн давуу талтай бизнесийн өрсөлдөгч бий болно.

50. Хуулийн төслийн 35.6-д “Шашны байгууллагын аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үүсгэн байгуулагч, гэрээгээр ажиллагсад болон бусад этгээдэд шууд болон шууд бус хэлбэрээр урамшуулал, ашиг болгон хуваарилахыг хориглоно” гэж заасан нь шашны байгууллагын өмч, эд хөрөнгө, бий болсон орлого өмчлөгч болох хандивлагч, дэмжигч нарын хяналтаас гарахгүй байхыг баталгаажуулсан заалт байна. Ингэснээр урт хугацааны турш бий болох их хэмжээний өмч, хөрөнгө зөвхөн “Хандивлагч”, “Дэмжигч” гэсэн гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний өмчлөлд төвлөрч байна.

51. Хуулийн төслийн 36.4, 36.5-д “сайн дурын ажилтан” гэдэг субъект шашны байгууллагад гэрээгээр ажиллаж болохоор заажээ. Ингэснээр шашны байгууллага нь шашны номлол түгээгчээс гадна дахин иргэдийг ажиллуулах боломжтой болж байна. Хуулийн төсөлд сайн дурын ажилтанд тавигдах шаардлага байхгүй, мөн тооны хязгаарлалт байхгүй учир зөвхөн гэрээ байгуулж, гэрээндээ зааснаар шашны бүхий л төрлийн үйл ажиллагаанд татан оролцуулах болохоор заалт байна. Ингэснээр шашны байгууллагуудынд хооронд “сайн дурын ажилтан” нэрийн дор иргэдийг өөртөө татах өрсөлдөөн явагдаж, улмаар иргэдийн дунд зөвхөн шашин шүтлэгээр бус гэрээ байгуулсан шашны байгууллагын харьяалалаар хуваагдал үүсэх нөхцөл бүрдэнэ.

52. Хуулийн төслийн 30.6-д “Шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагааг шашны номлол түгээгч явуулна” гэж заажээ. Гэтэл мөн төслийн 42.1-д “Монгол улсын иргэн нь аль нэг шашны байгууллагад харьяалагдахгүйгээр шашны сургаал, үзэл

номлол болон тухайн шашны зан үйл ёслол гүйцэтгэх, шашныг дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулна” гэж иргэн шашин дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулахаар заажээ. Энэ заалт нь хуулийн төслийн 30.7 “Шашны байгууллага нь энэ хуулийн 30.6-д заасны дагуу шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулах иргэнд тухайн шашны байгууллагаас төлөөлөх эрхтэйг нотолсон баримт бичгийг олгосон байна” гэсэнтэй зөрчилдөж байна.

53. Хуулийн төслийн 38 дугаар зүйлд шашны байгууллагын санхүүжилтийн тухай заасан байна. Төслийн 38.3 болон 38.5-д зааснаар шашны байгууллага нь гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнээс мөнгөн хандив болон бусад хөрөнгө, санхүүжилт авч зарцуулж, тайлагнахаар заажээ. Энэ заалтыг Хуулийн төслийн 12.4, 12.5, 12.6, 16.1 зэрэг заалттуудтай уялдуулан авч үзэхэд шашны байгууллагын эд хөрөнгийн өмчлөгч, Удирдах зөвлөлийн гишүүдийг бүрдүүлэгч болох хандивлагч, дэмжигч нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн байж болно гэдгийг баталгаажуулсан уялдаа холбоотой заалтууд байна.

54. Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийг (ШАЭЗ) дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллуулахаар Хуулийн төслийн 40.1-д тусгажээ. Дотоод асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яам бөгөөд сайд нь улс төрийн албан тушаалтан байдаг.

Тиймээс ШАЭЗ нь улс төрийн албан тушаалтаны удирдаж байгаа яамны дэргэд биш төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч гэдгээрээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд байх нь зохимжтой юм.

Тэгээд ч одоо мөрдөгдөж байгаа Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ард түмний эв нэгдэл, үндэсний аюулгүй байдлын эрх ашигт нийцүүлэн төр, сүм хийдийн олон шашин хоорондын харилцааг Монгол Улсын Ерөнхийлөгч зохицуулна” гэсэн заалтыг энэ хуулийн төсөлд орхигдуулсан байна.

Шашны асуудал эрхэлсэн Зөвлөлийн тэргүүнээр Хууль зүй дотоод хэргийн яамны сайд байхаар тусгасаныг шашны асуудал ямагт Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тэргүүний мэдэлд байсныг өөрчлөх гэсэн санаа хэмээн хардаж байна. Үндэсний аюулгүй байдалд шууд хамаарах асуудлыг ийнхүү Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тэргүүний харьяалалаас гаргахыг оролдож байгаа нь улсын үндэсний аюулгүй байдалд хор уршиг дагуулах эрсдэлтэй хэмээн үзэж байна.

55. Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн бүрэлдэхүүнд шашны байгууллагын төлөөллийг оруулахаар хуулийн төслийн 40.2-т заасан нь зохимжгүй болжээ. Ингэснээр шашны байгууллагатай холбоотой аливаа шийдвэр гаргахад сонирхлын зөрчил үүснэ.

56. Хуулийн төслийн 14.3-т зааснаар шашны байгууллагыг бүртгэх харилцааг Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулиар ердийн журмаар бүртгэж байна. Нийгмийн оюун санаанд маш их нөлөөтэй шашны байгууллага бусад төрийн бус байгууллагатай адил ердийн журмаар бүртгүүлж байгааг зөвшөөрч болохгүй. Шашны байгууллага нь тодорхой туршилтийн хугацаатай, түр зөвшөөрөлтэй байх зэрэг олон үе шаттайгаар үйл ажиллагаа явуулахаар хуульчлан зохилцуулах нь зүйтэй юм.

### **Дөрөв. Дүгнэлт**

“Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай” энэхүү хуулийн төслийн нэр болон агуулга нь Монгол Улс Үндсэн хуульдаа зааж өнөөдрийг хүртэл дагаж мөрдөж байгаа

шашин шүтэх, эс шүтэх эрхийг дахин хуульчилж хүний эрх, эрх чөлөөний хүрээнээс хальж төр, сүм хийдийн харилцааны асуудлыг бүхэлд нь зохицуулахыг оролдсон, хуулийн нэр, зорилго нь илт зөрчилдсөн төсөл болжээ гэж үзэж байна.

Хуулийн төсөлд үндэсний соёл, шашны уламжлалт нэр томъёогоо хэрэглээгүй, өмнө нь Монголд хэрэглэгдэж байгаагүй нэр томъёо, зохион байгуулалт, шашны практик үйл ажиллагаануудыг хуульчлахаар оруулжээ. Шинээр хэрэглэж буй нэр томъёо, ялангуяа шашны нэр томъёоны тайлбарыг хийгээгүй оновчтой бус тодорхойлолтуудыг маш их ашигласан байна. Тухайлбал, наминчлалын нууц, шашны бүлэг, шашны байгууллага, дэмжигч, хандивлагч, шашны номлол түгээгч, шашныг ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа, мөргөлийн газар гэсэн утга агуулга бүхий заалтуудыг олонтоо дурьдан хэрэглэжээ.

Хуулийн төсөл нь хуулийн нэрнээс эхлээд зорилго, хүрэхээр төлөвлөсөн үр дүн Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын шашинтай холбогдол бүхий зүйл, заалттай нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, Төсөл боловсруулсан ажлын хэсэг улс орныхоо үндэсний аюулгүй байдал, түүний дотор Монгол соёл иргэншлийн өв уламжлалыг хадгалан хамгаалах зорилгыг гол болгоогүй, эхнээсээ л шинээр нэвтрэн орж ирсэн гадны шашны бусад урсгалын үйл ажиллагааг хуулийн үндэслэлтэй болгон баталгаажуулах, улмаар бурхны шашныг эдгээр урсгалтай адилтган авч үзэх аргаар түүний уламжлалтыг бууруулах зорилго тавьж, гадаадын ашиг сонирхолд хөтлөгдсөн байж болзошгүй байна.

Үүнийхээ улмаас Монгол Улсын соёл, иргэншлийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй олон хүчин зүйлийг харгалзан үзээгүй, Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хайхрамжгүй хандсан байдал харагдаж байна. Монгол үндэстний оюун санааны нэгдмэл байдлыг хангах, хангуулах талаар тодорхой үзэл санаа хуулийн төсөлд тусгаагүй байна.

Мөн Монголын ард түмнийхээ олон зууны турш мөрдөж заншсан шашинд хандах ёс заншил болон соёлын өв, уламжлалыг тээгч олон зуун жилийн түүхтэй бурханы шашны онцлогыг үл харгалзан Монгол улсын буддистуудын шашин шүтэх эрх чөлөөг хязгаарласан, ялгаварласан зохицуулалтуудтай байна. Тухайлбал, хуулийн төслөөр Монголын Бурханы шашны Тэргүүн 10 дугаар Богдыг 14 нас хүртэл нь дахин тодруулж, ширээнд нь залахыг хоригложээ гэж дүгнэж байна. Улмаар хуулийн төсөл нь бурханы шашин, үндэсний уламжлал, эх түүх, соёл, зан заншлыг саармагжуулах далд санаа агуулсан төдийгүй Азийн, дорно дахины уламжлал, түүхийн дэлхийд үлдээсэн өвтэй Монгол орныг шашинаар дамжуулан шинээр зохион байгуулах санаа агуулсан байж болохоор байна.

Дэлхийд хамгийн түгээмэл тархсан шашны нэг бол буддын шашин бөгөөд уг шашныг монголчууд олон зуун жил шүтэж ирсэн, цаашид ч шүтэх болно гэдэг зарчмын асуудлыг хуулийн энэхүү төсөлд огт харгалзан үзээгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн Хоёрдугаар бүлгийн Арван зургаадугаар зүйлийн 15 дахь хэсэг “шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй” гэсэн заалт нь зөвхөн Монгол Улсын иргэнд хамааралтай заалт юм. Монгол Улс иргэнийхээ шашин шүтэх, эс шүтэх байдалд машид хүндэтгэлтэй ханддаг, уг харилцааг тухайлсан хуулиар эс зохицуулах хандлагыг баримталж ирсэн байна. Мөн төрт ёс, түүх, соёлын уламжлал, соёл иргэншлийн аюулгүй байдлаа уламжлалт бурханы шашны өв, соёлоос ангид авч үздэггүй байна.

Гэтэл энэ эрхийг гадаадын шашны байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд, гадаадын иргэн дэмжигч, гадаадын иргэн хандивлагч нарт шууд болон шууд бусаар хамааруулж, тэднийг Монгол улсад шашны үйл ажиллагаа чөлөөтэй явуулахыг хуульчлах зорилгоор хуулийн төслийг боловсруулжээ.

Мөн хууль нь “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай” гэсэн атлаа иргэний шашин эс шүтэх эрх чөлөөний тухай зохицуулалт хуулийн төсөлд огт байхгүй байна. Ийнхүү иргэний шашин шүтэх эрх чөлөөг зохицуулсан атлаа эс шүтэх эрхийг орхигдуулан ялгаварлажээ.

Тэгээд ч “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль”-ийн тодорхой зүйл заалтад хориг тавих, зүйл, заалтыг өөрчлөн найруулах замаар түүнийг сайжруулах боломжгүй байна. Төслийг боловсруулахдаа гаргасан санаатай, санаагүй олон алдааны улмаас тааламжгүй олон үр дагавар гарах, нийгэм, ард иргэд, шүтлэгтнүүдийн дунд зөрчил үүсгэж, шашин хоорондын тэмцлийн асуудал болгон хурцатгах байдалд хүргэж болзошгүй юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Төр, сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулна” гэж заасан. Үндсэн хуулийн Есдүгээр зүйлийн 3 дахь заалтаас харахад төр, сүм хийдийн хоорондын харилцааг л хуульчлахаар заасан байх бөгөөд иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хуулиар зохицуулна гэж Үндсэн хуульд заагаагүй байна. Гэтэл “шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай” хуулийн төсөлд төр, сүм хийд биш төр-шашны харилцааг зохицуулж, харилцааны хүрээг өргөтгөж, уламжлалт шашныхаа байр суурийг сулруулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар иргэнд баталгаатай эдлүүлэхээр заасан иргэний шашин шүтэх эс шүтэх, эрх чөлөөг дахин хууль гарган зохицуулалт хийх нь Монгол Улсын Үндсэн хуулийн Есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Төр, сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулна” гэж заасантай зөрчил үүсгэнэ. Одоо мөрдөгдөж байгаа Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг шинэчлэн найруулах замаар уг харилцааг улам боловсронгуй болгох боломжтой.

Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх нь Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.1-т заасан Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал, мөн хуулийн 3.4.7-д заасан монгол соёл иргэншлийн аюулгүй байдалтай холбоотой чухал асуудал болно. Иймд Төр, сүм хийдийн хоорондын харилцааны хуулийг шинэчлэн найруулах зорилго бүхий ажлын хэсгийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэд холбогдох шинжээч, салбар бүрийн эрдэмтэн, судлаачдын оролцоотойгоор тусгайлан байгуулж, төслийг боловсруулах нь чухал болжээ.


Улмаар төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч гэдгээрээ Монгол Улсын Ерөнхийлөгч хуулийг санаачлан УИХ-д өргөн барих нь зөв алхам болно. Ингэхдээ хуулийн төслийн үзэл баримтлалыг Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвшөөрөл авах нь зүйтэй.

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийг санаачлагч, зохиогч нь тодорхойгүй боловсруулахдаа судалгаагүй, үндэслэл муутай, үзэл баримтлал нь алдаатай, хуулийн заалтууд нь хоорондоо зөрчилтэй, хууль хийх арга, техник талаасаа учир дутагдалтай болжээ. Тэгээд ч шинэ хууль санаачилсан атлаа хуулийн төслийг “шинэчилсэн найруулга” гэж нэрлэсэн нь ойлгомжгүй байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын төрөөс өнөөдрийг хүртэл шашны асуудлаар баримталж ирсэн байр сууриас ухарч, улс орон, ард түмний оюун санаа, нийгмийн үнэт зүйлийг өөрчилж, шашнаар салган бутаргах, улмаар оршин тогтнохуй, соёл иргэншлийн аюулгүй байдалд хохирол учруулж болохуйц зүйл, заалттай, дотоодод болон гадаадад таатай бус байдал үүсэх нөхцлийг бүрдүүлжээ.

Тиймээс Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан уг хуулийн төслийг хэлэлцэхгүй байх нь зүйтэй гэж үзэж байна.

ШИНЖЭЭЧ:



Ж. БАТСУУРЬ


Биологийн шинжлэх ухааны доктор, профессор

Ж. БААТАР




Хууль зүйн ухааны доктор, хошууч генерал

З. БОЛДБААТАР




Цэргийн шинжлэх ухааны доктор, профессор,  
хошууч генерал

П. БАЯРСАЙХАН




Аюулгүй байдлын магистер, хурандаа

О. БАТСАЙХАН




Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор

А. ГАНБАТ




Цэргийн ухааны доктор, хошууч генерал

Я. ДОЛГОРЖАВ




Боловсролын шинжлэх ухааны доктор, профессор

Ж. ЛХАГВАДЭМЧИГ




Судлаач, докторант (доцент)

Л. МОЛОМЖАМЦ




Цэргийн шинжлэх ухааны доктор,  
дэслэгч генерал

Д. МЯГМАР




Шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал  
Геополитик судлалын хүрээлэнгийн захирал

Ч. ХАТАНБААТАР




Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн  
Ажлын албаны ахлах референт

Д. ТОД



Түүхийн ухааны доктор, профессор

О. ҮРЖИН



Цэргийн ухааны доктор, профессор, хошууч генерал

*Б. Ширэн*

Б. ШИРНЭН  
Хэл шинжлэлийн ухааны доктор *гэу проф*

*[Handwritten signature]*

Д. ЧИМЭД - ЮНДЭН  
Боловсролын ухааны доктор, хошууч генерал.

*[Handwritten signature]*

Л. ЭРДЭНЭЧУЛУУН  
Онц бөгөөд бүрэн эрхэт элчин сайд

*[Handwritten signature]*

Д. ӨЛЗИЙБААТАР  
Түүхийн ухааны доктор

*[Handwritten signature]*

*Ц. Энхбаяр*  
Мастер